

ДОРНОГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГА

БАТЛАВ



Н.ХОНГОРЗУЛ

### ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

**Дорноговь аймаг Сайншанд сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн баруун талд Нийтийн биеийн тамирын талбай шинээр байгуулах ажил**

*Нийтийн биеийн тамирын талбайн тохижилтын гадна хашааны урт 498м, бетон суурьтай 4 эгнээ гүйлтийн зам 1418,96м<sup>2</sup>, бетон суурьтай хиймэл зүлэгтэй хөлбөмбөгийн талбай 70.00x36.00, бетон суурьтай резин будагтай сагсан бөмбөгийн талбай 19.00x16.00, бетон суурьтай резин будагтай волейболын талбай 15.00x30.00, биеийн тамирын бялдаржуулах талбай, чөлөөт цагаа өнгөрөөх талбай 12.45x35.15, хүүхдийн тоглоомын талбай, 3 тавцант төмөр сандал 3ш, чийрэгжүүлэгчийн төхөөрөмж 6ш, хос турник 1ш, модон тавцантай сандал 23ш, гулсуур, хос савлуур, дүүжин даажин, сүүдрэвч 2ш, хуучин хашааны шонг будахаар төлөвлөсөн байна.*

А. Сайншанд сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн баруун талд Нийтийн биеийн тамирын талбай шинээр байгуулах ажлыг дараах Барилгын норм ба дүрэм /БНБД/ стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэх.

Б. Ажил гүйцэтгэх хугацааны график /хөдөлмөр зарцуулалт, үргэлжлэх хугацаа, ажиллах хүчний тоо/-ийг тодорхой гаргаж ирүүлнэ. Мөн ажлыг гүйцэтгэх технологи аргачлал, техникийн тодорхойлолтыг боловсруулж ирүүлнэ.

В. Талбайн зохион байгуулалтын зураг, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангах төслийн баримт бичгийг тухайн ажилд нийцүүлэн боловсруулах.

Г. Үнийн саналд зураг төслийн үнийг **13 782 800** төг тусган ирүүлэх ба "Барилгын төсөв зохиох дүрэм" БНБД 81-95-12\*(2020)-г мөрдлөг болгоно.

#### 1. Газар шорооны ажил:

Тохижилтын ажил гүйцэтгэхээр төсөлд тусгагдсан газарт хэмжилт хийж, тэгшилгээ нягтруулалт хийнэ.

Барилга барих талбайг бульдозероор тэгшлэн, талбайн хажууд байгаа овгор хэсгийн хөрсийг механизмаар түрж тэгшлэх. Талбайд нэмэгдэх хөрс нь овойлт, суулт үүсгэхгүй хөрсөөр дүүргэж автогрейдерээр тэгшилж доргиурт индүүгээр нягтруулна. Өнгөн хөрсийг гараар татаж тэгшлэн усалж, буталсан чулуун суурь /хайрган дэвсгэр үе/ байгуулах б=100мм.

Гүйлтийн замд чигийн гадаслгаа хийж, гүйлтийн зам, хөлбөмбөгийн талбайг М150 маркын бетоноор б=150мм зузаан цутгаж тэгшилгээ хийнэ. Сагс, волейболын талбай, дасгалын төхөөрөмжийн суурилуулах болон бусад талбайг М150 маркийн бетоноор б=150мм зузаан цутгаж тэгшилгээ хийнэ.

Сагсны талбай волейболын талбайн шалыг зориулалтын усанд тэсвэртэй, уян хатан чанар болон нарийн бүтэцтэй хүйтний агшилт, халууны тэлэлт үүсгэдэггүй резинэн будгаар 2 үе будах. Хөл бөмбөгийн талбайг зориулалтын үсний

нягтаршил сайтай, хамер артай зүлгээр бүрэх. Хүүхдийн тоглоомын талбайн шалыг 1,5см зузаан зориулалтын резинэн хавтангаар бүрэх.

Гадна талбайд лакан модон тавцантай, төмөр хөлтэй сандал. Сагс волейболын талбайд 3 давхар хуванцар тавцантай төмөр сандал суурилуулах.

Талбайд биеийн тамирын тоноглол /сагсны щит, волейболын тор шон, хөлбөмбөгийн хаалга, тор/ суурилуулах. Сүүдрэвч оройтой гурван тал руугаа урсгалтай гулсуур, хүүхдийн тоглоом, чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж суурилуулах. Сүүдрэвч, тоглоом тоноглол, гадна хашааны угсралтын ажлыг зураг төслийн дагуу хийж гүйцэтгэх.

Гадна төмөр сараалжин хашаа зураг төслийн дагуу угсарна. Хашааны шон 60\*60\*3, хэвтээ дай 40\*20\*2, босоо холбоос 20\*20\*2 хөндий төмрөөр хийнэ. Шонгийн суурь БМ100 маркын бетоноор цутгаж, зураг төслийн дагуу суулгах хэмжээнд хийнэ.

## **2. Гадна талбайн гэрэлтүүлэг:**

Одоо байгаа сургуулийн барилгын ЕС-1 самбараас шинээр групп тоноглон ГГУ самбарыг АВВБ-5х10мм.кв хөндлөн огтлолтой кабелиар зурагт үзүүлсний дагуу тэжээнэ. Нийтийн биеийн тамирын талбайн гэрэлтүүлгийг зам дагуу 6.Ом өндөртэй БОвт-ийн 12ш гэрэлтүүлэгч төлөвлөж АВВБ-4х10мм.кв кабелиар зурагт үзүүлсний дагуу тэжээнэ. Кабелийг газрын тэгшлэгдсэн түвшнээс доош 0,7м-ийн гүнд тавина. Газар шорооны ажил эхлэхээс өмнө зураг төсөлд тусгагдаагүй инженер шугам сүлжээ байгаа эсэхийг холбогдох газруудаас албан ёсоор тодруулсны дараа ажлыг эхэлнэ. Угсралтын ажлыг цахилгаан байгууламжийн дүрэм /БД43-101-03/ -ийн дагуу гүйцэтгэх хэрэгтэй. Бүх газар шорооны ажил, кабель угсралтын ажлын үед цахилгаан шугам сүлжээний байгууллагын төлөөлөгч байлцуулах хэрэгтэй.

- Ажлын үе шат бүрд фото зураг авч баталгаажуулна.

### **Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь:**

1. Тохижилтын ажлыг батлагдсан зураг төсөл, ажлын тоо хэмжээний дагуу чанарын өндөр түвшинд, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэнэ.

2. Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, БНБД, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.

3. Тохижилтын ажлыг эхлүүлэхдээ иргэдийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор анхааруулах тэмдэг тэмдэглэгээ байршуулах, хашаа барих зэрэг шаардлагатай арга хэмжээг авч гэнэтийн аюул осол гаргахгүй байхаар ажиллана.

4. Импортын материал сонгон худалдан авах тохиолдолд тохирлын гэрчилгээ, сертификат, паспорт, лабораторийн шинжилгээний дүнг хавсаргана. Үндэсний үйлдвэрийн материал сонгон авбал Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ, лабораторийн шинжилгээний дүн, үнийн баримтыг хавсаргана.

5. Барилгын талбайд ажлын журнал, батлагдсан зураг төсөл, хэрэглэгдэж буй материалын лабораторийн сорилтын дүн, тохирлын гэрчилгээ, гарал үүслийн бичиг баримтуудыг бэлэн байлгах шаардлагатай.

6. Гүйцэтгэсэн ажил тус бүрд ил, далд ажлын акт бичиж, схем зураг, фото зургаар баталгаажуулсан байна.

7. Тохижилтын ажлыг чанаргүй гүйцэтгэсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгнө.

8. Тохижилтын ажлыг зураг төсөлд зааснаас зайлшгүй тохиолдолд өөрчлөлт оруулах болбол захиалагч болон зураг төслийн байгууллагатай зөвшилцөнө. Зөвшөөрөлгүйгээр газар дээр өөрчлөхийг хориглоно.

9. Хэрэв материал хийц өөрчлөх тохиолдолд хүсэлтээ захиалагч байгууллагад бичгээр гаргаж хүсэлт гаргасан өдрөөс 7 хоногийн дотор хариу өгнө. Зөвшөөрөөгүй тохиолдолд зураг төсвийн дагуу гүйцэтгэнэ.

10. Гүйцэтгэгч нь барилгын ажлын ил, далд ажлын актыг баталгаажуулах, үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл хөтлөх, барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, зураг төсөл зохиогч, захиалагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг бүрэн биелүүлнэ.

11. Энэхүү техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, мэргэжлийн хяналтын улсын байцаагч эрхийнхээ дагуу барилгын ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй болно.

12. Монгол Улсын "Барилгын тухай" хуулийн 14.3-т /барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна/ 14.4-т /14.3-т заасан хугацаа дуусгавар болсон тохиолдолд гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч, захиалагч болон ашиглагч тухайн барилга байгууламжид хамтарсан үзлэг хийж, зөрчлийг арилгах талаар тэмдэглэл үйлдэнэ/ 14.5-д /14.4-т заасны дагуу зөрчлийг арилгаснаар 14.3-т заасан хугацаа дуусгавар болсонд тооцно/ 14.6-д /14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц, бүтээц, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж, тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа 3-аас доошгүй жил байна/ гэж заасныг үндэслэн гүйцэтгэгч байгууллага **чанарын баталгаа** гаргаж өгнө.

**ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ ХЯНАСАН:**


АЗДТГ-ЫН ХБТХОХ-ИЙН ДАРГА



/Ц.МӨНХ-ЭРДЭНЭ/

**ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОВСРУУЛСАН:**

АЗДТГ-ЫН ХБТХОХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН



/И.ГАНТУЛГА/